

ДБЭХС ТӨХК

**СААМ СУВИЛАЛД БИО 00 ХИЙХ АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/
Гэрээний дугаар:**

Саам сувилалд био 00 хийх ДБЭХС/202001055

Чойбалсан хот 2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Саам сувилалд био 00 хийх**

Тендерийн дугаар: **ДБЭХС/202001055**

Тендер зарласан огноо: **2020.03.09**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Саам сувилалын газарт био 00 хийх** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон харьцуулалтын баримт бичгийг www.tender.gov.mn хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000.0 (Тавин мянга) төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Үнийн саналыг **2020** оны **03** дугаар сарын 26 ны өдрийн **14** цаг **00** минутаас өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020** оны **03** дугаар сарын **26** ны өдрийн **14** цаг **10** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг,
“Дорнод бүсийн эрчим хүчний систем”ТӨХК-ийн төв байр,
Утас: 88078698, 99043832
Факс: 70584545**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон ажил гүйцэтгэлийн хуваарь
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Ажил гүйцэтгэлийн хуваарьт заасан ажил нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг |

заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨЭЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨЭЗ 1.1	<p>2019 оны санхүүгийн тайлан /аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> - Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан байна.) - Татварын албаны тодорхойлолт - Шүүхийн байгууллагын тодорхойлолт - Банк санхүүгийн байгууллагад өрийн үлдэгдэлгүй гэсэн тодорхойлолт - Гүйцэтгэх ажлын зураг, төсөв. - Оролцогч ирүүлж буй үнийн саналдаа Захиалагчийн албаны зардал, Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажил2% ийн зардлуудыг оруулан тооцно. - Объектыг ашиглаж эхэлснээс хойш бүх хэсэгт 3 жилийн баталгаа гаргах. /гадны нөлөөтэй гэмтэл болон байгалийн хүчин зүйлийн нөлөөллийн гэмтлийг тооцохгүйгээр/
ТӨЭЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Mb-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000.0 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 26 ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>
ТӨЭЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем”ТӨХК-ийн төв байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3 дугаар давхар, 301, 308 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 26 ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 10 минут</p>
ТӨЭЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Саам сувилалд био 00 хийх ДБЭХС/202001055</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:
2. Ажил хийгдэх газар: ***Дорнод аймаг Хэрлэн сум 1-р баг ДБЭХС ТӨХК-ийн саам сувилалын газар Хэрлэн голын тохойд***
3. Ажил гүйцэтгэлийн хуваарь: ***Гэрээ байгуулсанаас хойш хуанлийн 30-60 хоногийн дотор***

БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ОТГОНБААТАР

СААМ СУВИЛАЛД БИО 00 ХИЙХ АЖЛЫН ТЭХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Барилга барих талбайг тэгшлэх	M2	40
2	Гараар ухах	M3	0.4
3	Гараар эргүүлж булах	M3	0.09
4	Бетон бэлтгэл хийх B7.5	M3	2
5	Бетон шугаман суурь цутгах B20	M3	2
6	Сууринд хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	M2	4.8
7	Суурийн гадаргууд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх	M2	9.6
8	Ердийн тоосгоор энгийн гоёлтой 250 мм-ийн тоосгон хана цемент шохойн зуурмагаар гагнаж өрөх	M3	10
9	Төмөр бетон ялуу угсрах Я12.12.8	ш	2
10	Төмөр бетон ялуу угсрах Я15.12.14	ш	2
11	Гадна ханын бусад заслалаын ажилд 16 м хүртэл өндөр төмөр шат угсрах ба задлах	M2	8
12	Хамар хананд 3 м ² хүртэл талбайтай модон хаалга угсрах	M2	1.47
13	2 м ² дээш талбайтай хуванцар рамтай вакум цонх угсрах	M2	1.2
14	Цонхонд тавцан суулгах	M2	1
15	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	M2	1.2
16	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	M2	1.47
17	Хаалганд цоож суулгах	ш	1
18	Бетон шал хийх м 100	M3	1.32
19	Цементэн зуурмаг дээр вааран хавтанцар шал хийх	M2	16.5
20	Дотор тоосго ба бетон ханыг шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	M2	40

21	Цонх хаалганы тэгш гадаргуутай дотор амалгаа шавардах	M2	3
22	Хана таазанд замаска татах	M2	56
23	Эмульсээр тааз будах	M2	17
24	Шавардсан хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	M2	40
25	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	M2	20
26	Бохир усны хуванцар хоолой d-50	м	2
27	Бохир усны хуванцар хоолой d-100	м	3
28	Отвод 90/100	ш	1
29	Отвод 90/50	ш	1
30	Ташуу шулуун гуравлагч 100*100	ш	2
31	Ташуу шулуун гуравлагч 50*50	ш	1
32	Шалгах таг ф 100мм	ш	1
33	Суултуур байрлуулах том	1 ком	2
34	Шаазан угаалтуур тавих том	1ш	2
35	Системийг даралттай усаар шахаж шалгах	м	7
36	D-15 мм PVC хоолой угсрах	м	100
37	Хаалт голч d=15мм байрлуулах	ш	1
38	Системийг даралттай усаар шахаж шалгах	м	100
39	Холигч байрлуулах	1ш	2
40	Далд угсрах 1 туйлт ердийн унтраалга тавих	ш	1
41	Далд угсрах газардуулгын сэрээтэй хамгаалагдсан штепселийн залгуур тавих	ш	1
42	1*36 вт чадалтай өдрийн гэрэлтүүлэгч угсрах	ш	1
43	Унтраалга, розетка далд тавих хайрцаг	ш	2
44	Утас салбарлах хайрцаг	ш	1
45	1*2.5 мм 2 хөндлөн огтлолтой зэс голтой утас	м	100
46	Цооногийн нүх механизмаар ухаж овоолох	M3	5
47	Гараар засаж ухах	M3	0.5
48	Цооног ухаж шороог автосамосвалд ачих	M3	3
49	Гараар эргүүлж булах	M3	0.1
50	Цооногийн ул бетон цутгах БМ-150	M3	0.3
51	Цооногийн улны шавар тусгаарлалт, хана 2-ын хооронд битүмээр ус тусгаалалт хийх	M2	6
52	Бетон зуурмаг газар дээр нь зуурч бэлтгэх	M3	0.3
53	Угсармал төмөр бетон худаг угсрах ф 1000мм	ш	4

54	Худгийн модон таг угсрах	M2	2
55	Сувгийн нүх механизмаар ухаж овоолох	M3	3
56	Гараар засаж ухах	M3	0.2
57	Гараар эргүүлж булах	M3	34.5
58	Сувагт дулаалгатай паластмассан хоолой угсрах	M	4
59	Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага MNS 5924 : 2015 стандартад нийцэхүйц	-	-

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

ХҮХ-ИЙН ДАРГА

А.ТӨГСМАНДАХ

ХҮХ-ИЙН ИНЖЕНЕР

Н.БАТЗОРИГ

АЖЛЫН ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тодорхой- лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Гүйцэтгэлийн хамгийн эхний хугацаа	Гүйцэтгэх эцсийн хугацаа	Гүйцэтгэгч санал болгосон хугацаа
0	1	2	3	4	5	6	7	8
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								
20								
21								
22								
23								
24								

Дорнод аймаг“ ДБЭХС” ТӨХК-ийн Саам сувилал

Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор

Гэрээ байгуулсанаас хойш 60 хоногийн дотор

Дорнод аймаг“ ДБЭХС” ТӨХК-ийн Саам сувилал

Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор

Гэрээ байгуулсанаас хойш 60 хоногийн дотор

25								
26								
27								
28								
29								
30								
31								
32								
33								
34								
35								
36								
37								
38								

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Ажлын гүйцэтгэлийг гэрээ дүгнэх комиссын шийдвэр дээр үндэслэн , туршиж үзэж хүлээж авна. Туршилтаар болон дүгнэлтээр гарсан зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) Бараа материалуудыг дагалдаж ирэх үйлдвэрлэгчийн чанарын сертификат2) Барааны үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын дүгнэлт3) Гүйцэтгэх ажлын нэр, тоо ширхэгийн жагсаалт <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Шаардлагатай материалууд дээр үйлдвэрлэгчээс 12 сараас багагүй хугацаатай чанарын баталгаа ирүүлсэн байна.</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон компанийн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь</p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний нийт үнийн 10 хувиас хэтрэхгүй.</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]